



**Энэхүү баримт бичгийг  
Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (ICNL)-өөс гаргасан болно.**

ICNL нь иргэний нийгэм, олон нийтийн оролцооны эрх зүйн орчны талаарх мэдээллийн тэргүүлэх эх сурвалж юм. 1992 оноос хойш ICNL нь 90 гаруй орны иргэний нийгэм, засгийн газар, хандивлагчдад арга зүйн туслалцаа, зөвлөхийн үүрэг гүйцэтгэж ирсэн.

## **ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

ICNL-ийн цахим номын сангийн  
<http://www.icnl.org/knowledge/library/index.php>  
хаягаар орж, дэлхийн улс орнуудын судалгаа,  
мэдээллийн нөөцтэй танилцана уу.



International Center for Not-for-Profit Law  
1126 16th St., NW Suite 400  
Washington, DC 20036 USA  
Ph. 202-452-8600  
Fax 202-452-8555  
[infoicnl@icnl.org](mailto:infoicnl@icnl.org)

## ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Энэхүү иргэний нийгмийн байгууллагын тухай хууль тогтоомжид тусгавал зохих зүйл заалтуудын тухай үндсэн хяналтын хуудсыг одоо мөрдөгдөж байгаа эсхүл төслийн хэлбэртэй байгаа Ашгийн төлөө бус байгууллагын тухай хууль тогтоомж нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хэв загвартай нийцэж байгаа эсэхийг дүгнэхэд ашиглана. Энэ нь ICNL-ийн судалгааны ажилд үндэслэгдсэн болно. Олон улсад давамгайлж байгаа хэв загварыг тодорхойлохын тулд 100 гаруй улс орнуудын хууль болон тэдгээрийн тайланг цуглуулж задлан шинжилсэн болно. ICNL 150 гаруй улс орны мэдээллийг агуулсан цахим номын сан болон улс орны хууль, дүрэм журам, ёс зүйн дүрэм, Засгийн газар-ИНБ-ын хамтын ажиллагааны талаарх мэдээлэл зэргийг ICNL-ын [www.icnl.org](http://www.icnl.org) вэб хуудаснаас авч болно. Материалуудын цахим каталогийг мөн тэндээс харж болно.

### 1. ҮНДСЭН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ

- 1.1. Ашгийн төлөө бус байгууллага үүсгэн байгуулах: Тайван замаар цуглах, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх үндсэн эрх чөлөөг хамгаалах гэдэг нь Ашгийн төлөө бус байгууллагуудыг чөлөөтэй байгуулахыг зөвшөөрөх ёстой гэсэн утгатай. Мөн энэ нь хууль ёсны үйл ажиллагаа явуулахын тулд АТББ уудаас хуулийн этгээдийн шинжийг агуулсан байхыг шаардахгүй гэсэн утгатай.
- 1.2. АТББ-уудын бүртгэл /нэгтгэл/: АТББ-ыг хуулийн этгээдийнх нь хувьд бүртгэх эсхүл нэгтгэх явдлыг бүх этгээдүүдийн хувьд /бодгаль болон хуулийн этгээдийг хамруулаад/ харьцангуй хямд, хөнгөн, шуурхай байхаар АТББ -ын тухай хуульд тусгах ёстой.
- 1.3. Бүртгэлийн буюу нэгтгэх байгууллага: АТББ уудыг хууль зүйн хувьд байгуулагдсанд тооцох асуудлыг хариуцах төрийн эрх бүхий байгууллага нь мэдлэг чадвар бүхий мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, өөрийн үүргийг биелүүлэх бүрэн боломжтой байх ёстой ба АТББ-ыг бүртгэхгүй байх талаар түүний гаргасан шийдвэрийг хараат бус шүүхэд гомдлоо гаргах боломжтой байвал зохино. Хэрэв бүртгэлийн эсхүл нэгтгэх байгууллага нь шүүх бол түүний шийдвэрийг дээд шатных нь шүүхэд давж заалдах ёстой.
- 1.4. Улсын бүртгэл: АТББ-уудыг нэг эсхүл хэд хэдэн газар бүртгэж байгаагаас үл хамааран бүх АТББ- уудын нэгдсэн, үндэсний бүртгэл нь олон нийтэд хүртээмжтэй байх ёстой.
- 1.5. Үйл ажиллагааг зогсоох, цуцлах болон татан буулгах: АТББ-ын удирдах дээд байгууллага нь сайн дураараа үйл ажиллагаагаа зогсоох, хуулийн этгээдийн хувьд татан буугдах, өөрийн эд хөрөнгийг шүүхийн шийдвэр болон тухайн байгууллагын эрх ашигт нийцүүлэн хуваарилах эрхтэй байна. Бүртгэлийн буюу хяналтын байгууллага, эсхүл шүүхээс АТББ-уудыг зөвхөн ноцтой зөрчил

гаргасан бөгөөд тухайн эрх зүйн болон ёс зүйн зөрчлийг арилгах тухай хүсэлтээ гаргаагүй тохиолдолд албадан татан буулгах эрхтэй. Үндсэн эрхүүдийг зөрчөөгүйг батлах үүднээс бүх албадан татан буулгах ажиллагааг шүүхийн хяналтан дор явуулах ёстой.

1.6. Зөвшөөрөгдсөн зорилго болон үйл ажиллагаа:

а/ Ерөнхийдөө АТББ-уудыг бусад хуулийн этгээдүүдийн нэгэн адил авч үзэх бөгөөд тэдгээр нь өөрийн гишүүдийн ашиг сонирхол, олон нийтийн тусын тулд эсхүл “хүмүүнлэгийн” үйл ажиллагаа явуулж болно.

б/ АТББ нь улс нийтийг хамарсан бодлогын асуудлуудыг хэлэлцэх, боловсруулах гол оролцогчид бөгөөд нийгмийн ач холбогдол бүхий бүх асуудлуудаар, түүний дотор төрийн өнөөгийн болон хэтийн бодлого болон үйл ажиллагааны талаар чөлөөтэй хэлэлцүүлэг хийх, үг хэлэх эрхтэй байвал зохино.

с/ Тусгай зөвшөөрөл болон төрийн байгууллагын зохицуулалтад хамрагдах үйл ажиллагаа /эрүүлийг хамгаалах, БЗХӨ/ДОХ-той хүмүүст нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэрэг/ явуулдаг аль ч АТББ-д иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход болон зохицуулалтад тавигддагтай ижил шаардлага тавих

1.7. Хэвлэл мэдээлэл АТББ-ууд өөрийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр, түүний дотор төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах эрхтэй.

## 2. ИЛ ТОД БАЙДАЛ БОЛОН САЙН ЗАСАГЛАЛ

2.1. Удирдлагын баримт бичигтэй холбоотой заавал байх заалтууд. АТББ уудын удирдлагын баримт бичигт заавал тусгавал зохих, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь тавигдах шаардлагуудыг АТББ-ын тухай хуульд заах нь зүйтэй. Эдгээр шаардлагууд нь гишүүнчлэлтэй болон гишүүнчлэлгүй байгууллагуудын хувьд өөр өөр байж болох ба нэмэлт удирдах байгууллага /хяналтын зөвлөл, аудитын хороо зэрэг/-тай байх шаардлагыг гишүүнчлэлгүй байгууллагуудад тавьж болох юм.

2.2. Удирдлагын баримт бичгийн талаарх сонгох заалтууд АТББ ын тухай хуулиар АТББ-д хуулиар тогтоосон хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа болон удирдах бүтцээ тодорхойлох, өөрчлөх өргөн сонголтыг олгох.

2.3. Дотоод мэдээлэл болон Хяналт: Удирдах байгууллага болон түүний гишүүдийн үүрэг, хариуцлага

АТББ-ын удирдах дээд байгууллага /эсхүл түүний төлөөлөгч/-д тухайн АТББ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хүлээн авч, батлах шаардлага тавьж болно. Хуулиар АТББ-ын ажилтан болон зөвлөлийн гишүүд байгууллагадаа үнэнч байх, байгууллагын өмнө хүлээсэн үүргээ анхаарал болгоомжтой, нягт нямбай биелүүлэх, тухайн байгууллагын талаар нийтэд түгээгдээгүй мэдээллийн нууцыг хадгалах үүрэг ногдуулж болно.

2.4. Сонирхлын зөрчлийг хориглох Хуулиар АТББ –уудын үүсгэн байгуулагч, гишүүд, зөвлөлийн гишүүд болон ажил олгогчид тухайн АТББ-ын сонирхол болон тэдгээрийн хувийн буюу бизнесийн сонирхлын хооронд бодитой болон ирээдүйд үүсч болох зөрчлөөс зайлсхийх талаар хуульд нэмж заах асуудлыг анхааралтай авч үзэх

2.5. Ашиг орлого болон бизнесийн бусад орлогыг хуваарилахыг хориглох

а/ Үүсгэн байгуулагч, ажилтан, гишүүн, зөвлөлийн гишүүн, эсхүл ажил олгогчид АТББ-аас ашиг орлого болон хөлс харамж авахгүй байх талаар АТББ-ын тухай хуульд заавал зохино.

б/ АТББ-ууд татан буугдахдаа өөрийн үүсгэн байгуулагч, гишүүд, зөвлөлийн гишүүд, эсхүл ажил олгогчид өөрийн хөрөнгийг хуваарилан өгөх ёсгүй гэдгийг АТББ-ын тухай хуульд заавал зохино.

с/ АТББ-уудын хөрөнгө, орлого, ашгийг шууд болон шууд бус хэлбэрээр /тухайлбал, төрөл садангийн хүмүүст тэтгэлэг олгох/ үүсгэн байгуулагч, гишүүд, зөвлөлийн гишүүд,

ажил олгогч, АТББ уудтай холбогдсон хандивлагчдын хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглох тухай заалтыг АТББ-ын тухай хуульд оруулах нь зүйтэй.

2.6. Сайн дурын өөрийн-зохицуулалтын арга, зүйл. Бүх АТББ уудын удирдлагад тавигдах шаардлага, үйл ажиллагааны үндсэн стандартуудыг хуулиар тогтоох хэдий ч үйл ажиллагаа, ажил хэргийн өндөр стандартыг ёс зүйн дүрэм болон өөрийн зохицуулалтын журмаар тогтоохыг АТББ-уудад зөвшөөрч дэмжих ёстой.

2.7. Шүхэр байгууллагууд Сайн дурын өөрийн-зохицуулалтын зарчмуудыг хэрэгжүүлэх, батлах зорилгоор шүхэр байгууллагууд байгуулахыг нийгмийн зүгээс дэмжих болон хуулиар зөвшөөрөх ёстой.

### 3. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- 3.1. Сан бүрдүүлэх үйл ажиллагаа-Ерөнхий дүрэм, журмууд. Хууль ёсны болон зүй ёсны сан бүрдүүлэх бүх үйл ажиллагаа түүний дотор хаалганаас хаалганд, утас, шууд захиа, кампанит ажил, төлбөрт таавар, бооцоот тоглоом, сугалаа болон бусад сан бүрдүүлэх үйл ажиллагаа явуулахыг АТББ-уудад зөвшөөрөх ёстой. АТББ ын сан бүрдүүлэх зорилго бүхий төлбөрт таавар, бооцоот тоглоом, хүмүүнлэгийн зорилго бүхий үдэшлэг, дуудлага худалдаа болон бусад түр хугацааны үйл ажиллагаа нь сан бүрдүүлэх үйл ажиллагааны хэлбэр гэж тооцогдох бөгөөд түүнийг эдийн засгийн болон аж ахуйн үйл ажиллагаа гэж тооцох ёсгүй юм.
- 3.2. Сан бүрдүүлэх үйл ажиллагаа-Хязгаарлалт, Стандарт, Нөхөн төлбөр Олон нийтийн хандиваар сан бүрдүүлэхэд төрийн эсхүл хараат бус хяналтын байгууллагад бүртгүүлэх шаардлага тавих бөгөөд энэхүү байгууллага нь зөвшөөрөл, тэмдэг, болон бусад тодорхойлох материалуудыг сан бүрдүүлэгчдэд олгох, олон нийтийн хандиваар сан бүрдүүлэх үйл ажиллагаа явуулах стандарт тогтоох, нийтэд зориулсан мэдээлэл болон зүй бус үйл ажиллагааны төлөө хариуцлага тооцох эрхтэй.
- 3.3. Эдийн засгийн үйл ажиллагаа /i/ Тухайн АТББ нь ашгийн-төлөө-бус /соёл, боловсрол, эрүүл мэнд/ үйл ажиллагаа эрхлэх зорилготойгоор зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг, /ii/ үүсгэн байгуулагчид, гишүүд, ажилтан, зөвлөлийн гишүүд, эсхүл ажил олгогчид аливаа ашиг, орлого хуваарилахгүй гэсэн нөхцөлтэйгээр эдийн засаг, бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд оролцохыг АТББ-д зөвшөөрөх. Ийм үйл ажиллагааг эрхлэхдээ тусгай зөвшөөрөл буюу зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хангасан байх ёстой.
- 3.4. Орлогын эсхүл ашгийн татвараас АТББ уудыг чөлөөлөх Нийтэд эсхүл гишүүддээ үйлчлэхээр байгуулагдсан, гишүүнчлэлтэй эсхүл гишүүнчлэлгүй эсэхээс үл хамааран бүх АТББ –ын гишүүдийн тогтмол хураамж /хэрэв байдаг бол/, засгийн газраас /тэтгэлэг эсхүл гэрээгээр/, хандивлагчдаас авсан мөнгө буюу бусад үнэ бүхий зүйлүүдийг татвараас чөлөөлбөл зохино. АТББ-ын хөрөнгийг худалдсан, эсхүл хөрөнгөөс олсон үндсэн орлого,хувьцаа, хүү зэргийг татвараас чөлөөлөх эсэх асуудалд хандах хандлага өөр өөр байдаг бөгөөд нийгэмд үйлчлэхэд зориулагдах зүйлүүдэд ач холбогдол өгдөг байна.
- 3.5. Хандивд ногдох орлогын татвар Буяны үйл ажиллагаа болон сайн иргэншлийг дэмжих үүднээс хувь хүн болон бизнесийн байгууллагуудаас нийгэмд үйлчилдэг АТББ-уудад өгсөн хандивт хангалттай зохих татварын хөнгөлөлт үзүүлэх ёстой.
- 3.6. Эдийн засгийн үйл ажиллагаанд ногдуулах татвар АТББ уудад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх ёстой бөгөөд харин ийм үйл ажиллагаа нь тухайн байгууллагын гол зорилго, үйл ажиллагаа болох ёсгүй юм.АТББ-ын худалдаа эсхүл бизнесийн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашигт дараахь байдлаар хандаж болно:  
/a/ орлогын татвараас чөлөөлөх  
/b/ орлогын татварт хамруулах

/с/ зөвхөн худалдаа болон бизнес нь тухайн байгууллагын ашгийн-төлөө-бус зорилгод нийцэхгүй бол орлогын татварт хамруулах

/d/ эдийн засгийн үйл ажиллагаанаас олох ашгийн багахан хэсэг нь татварт үл хамруулах бөгөөд тогтоосон хязгаарлалтаас илүү гарсан хэсгийг татварт хамруулах

- 3.7. НӨТ, бусад татварууд, болон гаалийн татвар Нийгэмд үйлчилдэг АТББ ууд болон тэдгээрийн үйл ажиллагаанд НӨТ, бусад татвар /хөрөнгийн татвар/, болон гаалийн татварын хувьд нааштай хандвал зохих бөгөөд хууран мэхлэх, андуурах зэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хязгаарлалтуудыг хийх ёстойг анхаарах
- 3.8. Хандивыг дэмжих Хуулиудад хандив бүрдүүлэхийг дэмжсэн заалтууд оруулах ёстой. Эдгээр нь хандивын хэлбэртэй хувь оруулалтад тавигдах татварын тусгай нөхцөл, хөрөнгө оруулалтын нягт нямбай бодлого зэргийг агуулна.
- 3.9. Гадаадын сан Зохих журмын дагуу бүртгэгдэж, нэгтгэгдсэн АТББ нь гадаад орнуудын тусламжийн байгууллагууд, олон талт байгууллагууд, гадаад улсын тодорхой чиглэлийн болон хувийн донор байгууллагуудаас мөнгөн хөрөнгө болон бусад хандивыг гаалийн болон гадаад валютын тухай хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авах эрхтэй.
- 3.10. Сайн дурынхан Сайн дурынхныг АТББ –д ажиллахыг дэмжих бөгөөд ажил олгогчид ажиллагсаддаа сайн дурын ажил хийх цаг олгох явдлыг хуулиар дэмждэг байна.
- 3.11. ТББ-Засгийн газар хоорондын хамтын ажиллагаа Хуулиуд түүний дотор сонгон шалгаруулалттай холбоотой хууль тогтоомжид засгийн газар болон ТББ хоорондын хамтын ажиллагааг дэмжиж, засгийн газраас ТББ уудын явуулж байгаа төсөлд тэтгэлэг олгох, гэрээ байгуулах асуудлыг хамруулбал зохино.

#### **4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ БА НЭЭЛТТЭЙ БАЙХ**

- 4.1. Ерөнхий тайлан ТББ уудаас заавал шаардан авах бүх тайлангууд нь гаргаж өгөхөд хялбар бөгөөд төрийн байгууллагуудынхтай ижил хэлбэртэй байна.
- 4.2. Хяналтын байгууллагад тайлагнах  
АТББ уудад ерөнхий хяналт тавих асуудлыг хариуцсан холбогдох байгууллага /шүүх, яам, захиргааны байгууллага, эсхүл мэргэжлийн байгууллага/-д өөрийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргаж өгөх шаардлагыг /а/ Олон нийтэд ихээхэн хэмжээний тустай эсхүл олон нийтийн зүгээс ихээхэн хэмжээний дэмжлэг авдаг АТББ уудад тавьбал зохино. /б/ Мэдээлэлтэй холбоотой бүх шаардлагууд нь хандивлагч болон орлого хүлээн авагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан түүнчлэн нууц болон хувийн мэдээллийг хамгаалсан заалтуудыг агуулсан байх ёстой.
- 4.3. Хяналтын байгууллагаас тавих аудит  
/а/ Бүх хуулийн этгээдүүдийг хянан шалгах төрийн эрх мэдлийнхээ хүрээнд хяналтын байгууллага АТББ уудын бүртгэл, мэдээ болон үйл ажиллагааг ажлын цагаар, зохих ёсоор урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр шалгах эрхтэй. Энэхүү аудитын эрх мэдлийг иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд саад учруулах болон тухайн байгууллагад дарамт учруулах зорилгоор ашиглаж болохгүй.  
/б/ Хяналтын байгууллага хуульд нийцэж байгаа эсэхийг батлах үүднээс өөрт нь тайлан гаргаж өгсөн АТББ ууд дотроос таамгаар сонгож аудит хийх боловч ийнхүү аудит хийхдээ тухайн байгууллага болон түүнтэй холбоотой иргэдэд дарамт учруулах зорилготой байж болохгүй.
- 4.4. Татварын байгууллагуудад тайлагнах ба тэдгээрийн аудит Энэ нь татварын байгууллагад тусад нь гаргаж өгөх тайлантай холбоотой. Татвар тус бүрийн /ашгийн татвар, НӨТ зэрэг/ хувьд өөр өөр мэдээ шаардагдаж болох юм.
- 4.5. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад тайлагнах болон тэдгээрийн аудит Төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай үйл ажиллагаа эрхэлж буй АТББ нь хувь хүмүүс болон бизнесийн

байгууллагуудаас холбогдох байгууллагад гаргаж өгдгийн нэгэн адил тайлан гаргаж өгөхийг шаардах ёстой.

- 4.6. Олон нийтэд мэдээлэл нээлттэй болон хүртээмжтэй байх Томоохон үйл ажиллагаа, хөрөнгөтэй эсхүл олон нийтийн дэмжлэг бүхий АТББ уудаас санхүүгийн болон үйл ажиллагааныхаа ерөнхий тайланг олон нийтэд зориулан гаргахыг шаардаж болно. Энэхүү тайлан нь ерөнхий хяналтын байгууллага, татварын байгууллага болон тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад гаргаж өгдгөөс товч байж болох бөгөөд хувийн болон нууц мэдээллийг хамгаалахаас гадна орлого хүлээн авагч болон хандивлагчдын нэрийг нууцлахыг зөвшөөрч болно.
- 4.7. Тусгай хариуцлага АТББ –д бусад хуулийн этгээдүүдэд ногдуулдагтай ижил ерөнхий хариуцлага /гэрээний болон гэм хор учруулснаас үүсэх хариуцлага/ хүлээлгэх бөгөөд зөвхөн АТББ-уудад хамааралтай зөрчил /хувьдаа завших, сан бүрдүүлэх зүй бус үйл ажиллагаа, татварын хууль тогтоомжид заасан тусгай журам/-д хүлээлгэх тусгай хариуцлага /торгууль болон шийтгэлийн татвар, албадан татан буулгах боломж/-ыг зааж өгвөл зохино.